



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

XV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Зохион байгуулалт: Улсын онцгой комиссын хуралдаан 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 10.00 цагт Төрийн ордноос цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын динамик, зүй тогтлын талаар:

*МУИС-ийн Физикийн тэнхмийн судлаач,  
доктор Т.Бэгзсүрэн,*

2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах эсэх талаар санал:

*Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой  
комиссын гишүүн С.Энхболд,*

3. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын хавсралтад өөрчлөлт оруулах тухай:

*Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,  
бригадын генерал Г.Ариунбуян,*

4. Хил нээх талаар:

*Улсын онцгой комиссын гишүүн,  
Гадаад харилцааны сайд,  
Б.Батцэцэг*

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН 2021 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДРИЙН 15 ДУГААР  
ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР

Улсын онцгой комиссын 15 дугаар хуралдаан 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 10.00 цагаас цахимаар хуралдаж, хуралдаанаас дараах шийдвэрийг гаргаж хэрэгжүүлэхээр тогтов.

*Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Улсын онцгой комиссын орлогч дарга Улсын онцгой комиссын орлогч дарга, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян нарт:*

1.1. Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд 14 хоногоор сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

1.2. “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын хавсралтад өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

*Хоёр. Улсын онцгой комиссын, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга Ц.Ганзориг нарт:*

2.1. Нийслэлийн хэмжээнд 1-р тунгын дархлаажуулалтад хамрагдсан иргэдийг 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн дотор 2-р тунд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах;

2.2. Дархлаажуулалтад хамрагдаагүй иргэдийн 1-р тунг вакцины татан авалттай уялдуулж, нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан, бүрэн хамруулж дуусгах;

2.3. Иргэдийг дархлаажуулалтад хамруулах үйл ажиллагаатай холбогдуулан дархлаажуулалтын цэгүүдэд бөөгнөрөл, эмх замбараагүй байдал үүсгэхгүйгээр хуваарь, төлөвлөгөө гарган байршлыг тодорхой болгож, иргэд олон нийтэд тухай бүр мэдээллийн хэрэгслээр мэдээлж байх;

*Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Хууль зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зам тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт:*

3.1. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хатуу хяналт тавьж, тээврийн хэрэгслийг цахим “QR” кодын зохицуулалтаар хөдөлгөөнд оролцуулах;

3.2. Тээврийн хэрэгслийг цахим “QR” кодын зохицуулалтаар хөдөлгөөнд оролцуулахтай холбогдуулан Ажлын хэсгийг байгуулж, ажиллах;

3.3. Төрийн албан хаагчдыг 10 хүртэл хувиар ажиллуулах, тогтоосон цагийн хуваариар замын хөдөлгөөнд оролцуулах;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Гадаад харилцааны сайд, Б.Батцэцэг, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Бригадын генерал Х.Лхагвасүрэн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр нарт:

4.1. Агаарын замын боомтыг харилцан адил нөхцөлөөр үе шаттай нээх тухай яриа хэлэлцээг манай улсаас шууд нислэг үйлддэг улсуудтай эхлүүлж, КОВИД-19-ын халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан, шинжилгээ хийлгэсэн тухай гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд иргэд зорчих нөхцөлийг сэргээх;

4.2. Монгол Улсаас Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдаж, шинжилгээ өгсөн гэрчилгээ бүхий зорчигчийг хил нэвтрүүлэх асуудлыг талууд харилцан хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Монгол, Оросын хилийн Алтанбулаг-Хиагт авто замын боомт, Монгол, Хятадын хилийн Замын-Үүд-Эрээн авто замын боомтоор зорчигч тээврийн хөдөлгөөнийг үе шаттай сэргээх, эхний ээлжинд вакцины бүрэн тунд хамрагдсан иргэдийг нэвтрүүлэх чиглэлээр яриа хэлэлцээ хийх;

4.3. Дотоодын халдварын нөхцөл байдал, нийт хүн амыг дархлаажуулах арга хэмжээтэй уялдуулан 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн гадаадын жуулчдыг хүлээж авах бэлтгэлийг хангах, аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах холбогдох журмыг батлуулах;

4.4. Шаардлага хангасан гадаадын жуулчдад зохих ангиллын визийг 2021 оны 5 дугаар сард багтаан олгож эхлэх, гадаад улстай байгуулсан визгүй зорчих хэлэлцээрийг хэрэгжүүлэхийг Гадаад харилцааны яам, Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад зөвшөөрөх.

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, хурандаа Ж.Амгалан, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА  С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ХУРАНДАА  Ж.АМГАЛАН